



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын
Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/106/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn
Дорноговь аймаг
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn
Аудитор: Т.Мөнхтогтох
Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

**ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.АЛТАНЦАЦРАЛ ТАНАА**

2020.02.21 № 4-6/114
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Тамгын газрын дарга Г.Алтанцацрал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 18-аас 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/30 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлага, төрийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэхэд оршино.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “acalous” программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 30 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 329,094.2 мянган төгрөгөөс тооцон 3,290.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,918.3 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,151.4 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	2,091.4	0.0	-2,091.4
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	87,432.9	145,662.6	58,229.7
Үндсэн хөрөнгө	1,482,228.6	1,523,379.9	41,151.4
Нийт хөрөнгө	1,571,752.9	1,669,042.6	97,289.7
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,571,752.9	1,669,042.6	97,289.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,571,752.9	1,669,042.6	97,289.7

Авлагаа барагдуулсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүсгэсэн 2,091.4 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагад Төрийн аудитын газар акт тогтоосон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн биеийн тамирын задгай талбайг Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдан нөхцөл байдлыг үнэлэн бусад хангамжийн дансандаа 57,289.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус бүрээр бүртгэж авсан бөгөөд малчдын өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангах зорилгоор 8,680.0 мянган төгрөгөөр өвс тэжээл худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 119,503.7 мянган төгрөгөөр өссөн бөгөөд төсвийн хөрөнгөөр 9,051.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, аймгийн Засаг даргаас Бүрдэнэ багийн Засаг даргад 1,800.0 мянган төгрөгийн компьютер, аймгийн хөрөнгө оруулалтаар 18,087.7 мянган төгрөгийн гүн өрмийн худаг, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас 65,0 мянган төгрөгийн ном, аймгийн хөрөнгө оруулалтаар 57,500.0 мянган төгрөг биеийн тамирын задгай талбайн бетон гүйлтийн зам, аймгийн хөрөнгө оруулалтаар 33,000.0 төгрөгийн фургон авто машин үнэ төлбөргүй авсан байна. 581,437.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл бодогдсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,669,042.6 мянган төгрөг болж 97,289.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй байна.

Биет бус хөрөнгө 950.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд сумын Засаг даргын Тамгын газрын вэб сайт хийлгэсэн байна.

Өр төлбөр байхгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын тайлант онд 1,000.0 төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 480.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 48 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Түрээсийн орлого	1,000.0	480.0	520.0	48
Нийт дүн	1,000.0	480.0	520.0	48

Түрээсийн орлого 520.0 мянган төгрөгөөр тасарсан нь 2 албаны байртай бөгөөд 1 албаны байр нь ашиглалт муудаж, амьдрах нөхцөлгүй болсноос шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 8 зориулалтад 396,046.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 395,246.7 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 800.0 мянган төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 395,046.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 395,526.7 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 231,012.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 28,868.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 63,224.0 мянган төгрөг, хангамж бараа материал 23,822.8 мянган төгрөг, нормативт зардал 702,0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 11,357.3 мянган төгрөг, томилолт зочны зардал 3,943.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 23,246.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 7,799.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 800.0 мянган төгрөг/ нийт дүнгээр 749.9 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Онцгой байдлын газраас 81,018.2 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 2,533.2 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас 14,560.0 мянган төгрөг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 3,929.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого цахим тендерийн үнэ 742.5 мянган төгрөг, өвсний үнэ 14,829.2 мянган төгрөг нийт 117,513.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,572.8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 369.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 550.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 109,438.4 төгрөг нийт 111,930.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,582.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 239,815.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 239,335.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 180.3 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 300.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 180.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 180.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. 2019 оны 11 дүгээр сард Дөрвөлж багийн Засаг дарга Б.Буянжаргалд 400,000 төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, 180,356 төгрөгийг буцаан суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.3.2 “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд нь, үнэн зөв ... бүртгэж тайлагнах”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалт, (үнэн зөв байдал) батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,091.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 2,091.4 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

1.1 Илрүүлэлт:

Бараа материал, үндсэн хөрөнгийг дансны ангиллын дагуу бүртгээгүй.

Энэ нь (үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээ, бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, бүх орлого, бүх зардал, НББОУС-аар тогтоосон бусад зүйлсийг заавал бүртгэнэ” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.15 “бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно” заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын дагуу бараа материалыг бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>89,524,325.23</u>	<u>85,563,605.76</u>
33	АВЛАГА	2,091,432.47	00.00
335	Бусад авлага	2,091,432.47	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,091,432.47	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,432,892.76	85,563,605.76
354	Хангамжийн материал	87,432,892.76	85,563,605.76
35410	Бичиг хэргийн материал	1,456,424.00	1,478,884.00
35420	Аж ахуйн материал	3,103,288.00	2,336,880.00
35470	Бусад хангамжийн материал	82,873,180.76	81,747,841.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,482,228,576.91</u>	<u>1,583,478,946.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,482,228,576.91	1,583,478,946.34
392	Биет хөрөнгө	1,389,544,576.91	1,489,844,946.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,647,199.00	618,647,199.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,433,000.00	-37,389,547.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	183,360,870.00	216,360,870.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-131,829,451.90	-162,812,726.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119,246,675.53	129,147,675.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,361,326.88	-106,495,080.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,411,887.78	27,411,887.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,177,800.12	-18,463,674.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	942,343,642.53	1,078,030,342.53
39215	Хуримтлагдсан элэгдэл	-241,433,579.03	-255,426,459.54
39217	Ном	769,460.00	834,460.00
393	Биет бус хөрөнгө	92,684,000.00	93,634,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	93,534,000.00	94,484,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-850,000.00	-850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,571,752,902.14</u>	<u>1,669,042,552.10</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,571,752,902.14</u>	<u>1,669,042,552.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,571,752,902.14	1,669,042,552.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	528,431,611.57	528,431,611.57
51101	Өмч: - төрийн	92,684,000.00	92,684,000.00
51102	- хувийн	435,747,611.57	435,747,611.57
512	Хуримтлагдсан үр дүн	818,313,087.81	915,602,737.77
51210	Өмнөх үеийн үр дүн	818,313,087.81	818,313,087.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	97,289,649.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	225,008,202.76	225,008,202.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,571,752,902.14</u>	<u>1,669,042,552.10</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	296,814,945.05	689,128,738.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,814,429.05	192,140,731.00
120	Нийтлэг татварын бус орлого	49,814,429.05	192,140,731.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,814,429.05	192,140,731.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,233,500.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,965,500.00	16,051,680.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,615,429.05	176,089,051.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	247,000,516.00	496,988,007.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	161,858,600.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	161,858,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,092,812.00	101,941,307.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,092,812.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	101,941,307.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	395,046,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	395,046,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,049,104.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,049,104.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	317,136,236.20	591,839,088.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,136,236.20	591,839,088.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314,827,132.20	584,956,389.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106,557,947.00	233,856,784.93
210101	Үндсэн цалин	105,837,947.00	233,856,784.93
210105	Гэрээт ажлын хөлс	720,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,609,069.00	29,733,001.52
210201	Тэтгэврийн даатгал	8,405,946.00	19,217,992.12
210202	Тэтгэмжийн даатгал	1,050,806.00	3,890,320.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	840,705.00	1,907,547.00
210204	Ажилгүйдлийн даатгал	210,101.00	460,769.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,101,511.00	4,256,373.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,472,627.00	63,224,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,662,502.00	5,286,100.00
210302	Түлш, халаалт	1,290,000.00	56,905,200.00
210303	Цэвэр, бохир ус	520,125.00	1,032,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,322,290.00	30,736,833.00
210401	Бичиг хэрэг	642,295.00	5,133,400.00
210402	Тээвэр, шатахуун	26,283,360.00	19,232,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,531,335.00	2,059,235.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,080,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	785,300.00	4,151,608.00
2105	Нормативт зардал	724,000.00	92,850.00
210502	Хоол, хүнс	724,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	92,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000.00	3,364,530.00
210604	Урсгал засвар	30,000.00	3,364,530.00
2107	Томилолт, зочны зардал	1,912,000.00	3,943,900.00
210702	Дотоод албан томилолт	1,912,000.00	3,943,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,567,830.75	121,580,259.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,912,780.75	120,039,295.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	402,550.00	560,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	525,586.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	178,478.00
210807	Газрын төлбөр	87,500.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,631,368.45	98,424,230.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,193,650.00	18,222,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,849,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,437,718.45	78,352,330.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,309,104.00	6,882,699.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,309,104.00	550,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,049,104.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,260,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	6,332,699.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,332,699.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-20,321,291.15	97,289,649.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-20,321,291.15	97,289,649.96

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	251,199,516.00	513,039,687.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,199,000.00	16,051,680.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,199,000.00	16,051,680.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,199,000.00	16,051,680.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,233,500.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,965,500.00	16,051,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	247,000,516.00	496,988,007.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	161,858,600.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	161,858,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,092,812.00	101,941,307.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,092,812.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	101,941,307.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	395,046,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	395,046,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,049,104.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,049,104.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	219,528,239.00	503,988,687.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	219,528,239.00	503,988,687.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,219,135.00	496,855,987.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,281,800.00	231,012,577.27
210101	Үндсэн цалин	101,681,800.00	219,492,577.27
210105	Гэрээт ажлын хөлс	3,600,000.00	11,520,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,634,200.00	28,868,209.71
210201	Тэтгэврийн даатгал	8,422,700.00	19,812,035.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,052,900.00	1,891,370.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	842,500.00	2,184,334.00
210204	Ажилгүйдлийн даатгал	210,400.00	452,933.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,105,700.00	4,527,537.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,947,949.00	63,224,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,488,249.00	5,286,100.00
210302	Түлш, халаалт	00.00	56,905,200.00
210303	Цэвэр, бохир ус	459,700.00	1,032,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,425,476.00	25,059,645.00
210401	Бичиг хэрэг	836,000.00	3,457,610.00
210402	Тээвэр, шатахуун	9,584,306.00	18,623,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	876,770.00	2,521,105.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	128,400.00	297,900.00
2105	Нормативт зардал	00.00	702,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	702,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000.00	3,961,330.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	235,000.00
210604	Урсгал засвар	30,000.00	3,726,330.00
2107	Томилолт, зочны зардал	2,177,000.00	3,943,900.00
210702	Дотоод албан томилолт	2,177,000.00	3,943,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,907,920.00	132,684,826.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,252,870.00	131,144,340.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	402,550.00	667,741.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	418,745.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	178,000.00
210807	Газрын төлбөр	87,500.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	814,790.00	7,399,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	814,790.00	5,550,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,849,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,309,104.00	7,132,699.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,309,104.00	800,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,049,104.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,260,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	6,332,699.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,332,699.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,671,277.00</u>	<u>9,051,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	9,051,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	9,051,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	9,051,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	9,051,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-9,051,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,671,277.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,671,277.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,747,611.57	223,546,579.16	784,635,469.70	1,443,929,660.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,747,611.57	223,546,579.16	784,635,469.70	1,443,929,660.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	221,308,712.00	00.00	-20,321,291.15	200,987,420.85
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	818,313,087.81	1,571,752,902.14
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	818,313,087.81	1,571,752,902.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	818,313,087.81	1,571,752,902.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	97,289,649.96	97,289,649.96
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	915,602,737.77	1,669,042,552.10

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	396,046,700.00	394,776,811.98	1,269,888.02	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	396,046,700.00	394,776,811.98	1,269,888.02	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,246,700.00	393,976,811.98	1,269,888.02	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,012,600.00	231,012,577.27	22.73	100.0
210101	Үндсэн цалин	219,492,600.00	219,492,577.27	22.73	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	11,520,000.00	11,520,000.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,726,600.00	28,868,209.71	858,390.29	97.1
210201	Тэтгэврийн даатгал	20,492,600.00	19,812,035.71	680,564.29	96.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,846,900.00	1,891,370.00	-44,470.00	102.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,308,500.00	2,184,334.00	124,166.00	94.6
210204	Ажилгүйдлийн даатгал	461,700.00	452,933.00	8,767.00	98.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,616,900.00	4,527,537.00	89,363.00	98.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,239,500.00	63,224,000.00	15,500.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,286,100.00	5,286,100.00	00.00	100.0
210302	Түлш, халаалт	56,920,700.00	56,905,200.00	15,500.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,032,700.00	1,032,700.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,831,000.00	23,822,845.00	8,155.00	100.0
210401	Бичиг хэрэг	3,450,800.00	3,507,610.00	-56,810.00	101.6
210402	Тээвэр, шатахуун	17,050,300.00	17,050,230.00	70.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,864,000.00	2,807,105.00	56,895.00	98.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168,000.00	160,000.00	8,000.00	95.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	297,900.00	297,900.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	702,100.00	702,000.00	100.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	702,100.00	702,000.00	100.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,380,000.00	11,357,330.00	22,670.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	8,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	3,380,000.00	3,357,330.00	22,670.00	99.3
2107	Томилолт, зочны зардал	3,948,300.00	3,943,900.00	4,400.00	99.9
210702	Дотоод албан томилолт	3,948,300.00	3,943,900.00	4,400.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,606,600.00	23,246,450.00	360,150.00	98.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,706,000.00	21,705,964.00	36.00	100.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	228,000.00	216,000.00	12,000.00	94.7
210803	Даатгалын үйлчилгээ	965,000.00	667,741.00	297,259.00	69.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	457,600.00	418,745.00	38,855.00	91.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	190,000.00	178,000.00	12,000.00	93.7
210807	Газрын төлбөр	60,000.00	60,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,800,000.00	7,799,500.00	500.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800,000.00	2,799,500.00	500.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800000.00	800000.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	396,046,700.00	395,526,700.00	520,000.00	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	395,046,700.00	395,046,700.00	00.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	395,046,700.00	395,046,700.00	00.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	480,000.00	520,000.00	48.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	480,000.00	520,000.00	48.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	111,930,176.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	111,930,176.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	111,930,176.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	1,572,800.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	1,572,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	369,000.00
210604	Урсгал засвар	0.00	369,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	109,438,376.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	109,438,376.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	550,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	550,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	101941307.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	101,941,307.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	101,941,307.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		